



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 12 (149)

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг:**

- *М.Борбаатарт хошууч генерал цол хүртээх тухай*
- *Д.Мягтарт хошууч генерал цол хүртээх тухай*
- *Ёндондүйчирийн Ганбатад Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай*
- *Цэвэлийн Должинсүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай*
- *Дотейн Даштуанд Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээх тухай*

**Монгол Улсын Засгийн газрын тогтоол:**

- *Төрийн ёслолын журам батлах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**

**Улаанбаатар хот  
2000 он**



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны дөрөвдүгээр сарын 10 № 12 (149)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |   |           |     |
|---|-----------|-----|
| 155. М.Борбаатарт хошууч генерал цол хүртээх тухай                                      | Дугаар 30 | 259 |
| 156. Д.Мягмарт хошууч генерал цол хүртээх тухай   | Дугаар 31 | 259 |
| 157. Ёндондүйчирийн Ганбатад Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай  | Дугаар 32 | 260 |
| 158. Цэвэлийн Должинсүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 33 | 260 |
| 159. Дотейн Даштуанд Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээх тухай                     | Дугаар 34 | 260 |
| 160. Зэвсэгт хүчний зарим генерал, офицер, ахлагч нарыг одон, медалиар шагнах тухай     | Дугаар 35 | 260 |
| 161. Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай  | Дугаар 37 | 263 |
| 162. Төрийн ёслолын журам батлах тухай  | Дугаар 24 | 263 |

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

**М.Борбаатарт хошууч генерал цол хүртээх тухай**

Зэвсэгт хүчний Ерөнхий штабын сургалт зохион байгуулалт эрхэлсэн орлогч дарга Михлайн Борбаатарт

хошууч генерал цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

**Д.Мягмарт хошууч генерал цол хүртээх тухай**

Батлан хамгаалахын их сургуулийн захирал Довчингийн Мягмарт хошууч генерал

цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

**Ёндондүйчирийн Ганбатад Монгол улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Цэргийн хөгжмийн албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж үлээвэр хөгжмийг хөгжүүлэх, сурталчлах, цэргийн хөгжмийн боловсон хүчин бэлтгэх, тэдний ур чадварыг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Зэвсэгт хүчний ерөнхий штабын хөгжмийн албаны дарга,

Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн дарга, хурандаа Ёндондүйчирийн Ганбатад Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

**Цэвэлийн Должинсүрэнд Монгол улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Цэргийн оёдлын үйлдэрт олон жил үр бүтээлтэй ажиллаж цэргийн дүрэмт хувцас оёх үйлдвэрлэлийн төлөвлөгөөт даалгаврыг тогтмол давуулан биелүүлж, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилчид бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" компанийн оёдолчин, мастер багш Цэвэлийн Должинсүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

**Дотейн Даштуанд Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээх тухай**

Иргэний агаарын тээврийн байгууллагад удаан жил үр бүтээлтэй ажиллаж олон улсын болон дотоодын агаарын шугамуудыг шинээр нээх нислэгийн хариуцлагатай үүргийг зөрчил сааталгүй, өндөр түвшинд гүйцэтгэж, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулсан хувь

нэмрийг нь үнэлж Дэд бүтцийн улсын хяналтын албаны нислэг техникийн хяналтын улсын байцаагч Дотейн Даштуанд Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

**Зэвсэгт хүчний зарим генерал, офицер, ахлагч нарыг одон, медалиар шагнах тухай**

Зэвсэгт хүчний албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж эх орноо батлан хамгаалах үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан генерал, офицер, ахлагч

нарыг одон, медалиар шагнасугай.

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН  
ОДОНГООР:**



1. Мягмарын Лхагвасүрэн - Батлан хамгаалах яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, хурандаа

2. Юмчингийн Содов - Зэвсэгт хүчний ерөнхий штабын ар талын газрын орлогч дарга, хурандаа

3. Осорнамжимын Чулуунбаатар - Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний ерөнхий штабын Үйлчилгээ, аж ахуйн газрын дарга, хурандаа

4. Бадамын Шагдар - Зэвсэгт хүчний ерөнхий штабын 1 орлогч, Цэргийн удирдлага, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, хошууч генерал

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Цэрэндоржийн Бааст - Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн захирагч, хурандаа

2. Раднаагийн Батдэлэгр - Зэвсэгт хүчний 318 дугаар ангийн захирагч, хурандаа

3. Тойвоогийн Баттөмөр - Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн захирагч, хурандаа

4. Ванчинсүрэнгийн Бат-Эрдэнэ - Батлан хамгаалах яамны Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн, хурандаа

5. Шаравын Будаев - Зэвсэгт хүчний ерөнхий штабын хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын орлогч дарга, хурандаа

6. Жагваралын Бямба-Очир - Батлан хамгаалахын их сургуулийн цэргийн албаны офицер, дэд хурандаа

7. Дансрангийн Ванчинсүрэн - Зэвсэгт хүчний клинкийн төв эмнэлгийн сэхээн амьдруулах, мэдээгүүжүүлэх тасгийн их эмч, дэд хурандаа

8. Гунгаагийн Гүрбазар - Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Зэвсэглэл, техник туршилт, зохион бүтээх төвийн дарга, дэд хурандаа

9. Чүлтэмийн Даваасүрэн - Зэвсэгт хүчний 228 дугаар ангийн штабын дарга, дэд хурандаа

10. Төмөрбаатарын Далхаасүрэн - Батлан хамгаалах яамны Бодлогын

хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, хурандаа

11. Дугарын Жаргалсайхан - Зэвсэгт хүчний ерөнхий штабын Хяналт, шижилгээ, үнэлгээний газрын хяналтын улсын байцаагч, дэд хурандаа

12. Литэвийн Зунаа - Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн захирагчийн 1 орлогч, штабын дарга, дэд хурандаа

13. Жамсрангийн Машбаатар - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн захирагч, хурандаа

14. Шагдарсүрэнгийн Мөнхсайхан - Зэвсэгт хүчний ерөнхий штабын тагнуулын хэлтсийн дарга, хурандаа

15. Асхарын Муратхан - Батлан хамгаалахын их сургуулийн Хилийн цэргийн сургуулийн тэнхмийн эрхлэгч, хурандаа

16. Амирсултаны Нурамхаан - Зэвсэгт хүчний 318 дугаар ангийн тагнуулын дарга, хошууч

17. Батжаргалын Отгон-Уул - Батлан хамгаалах яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын орлогч дарга, хурандаа

18. Сэрээнэнгийн Төрсайхан - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

19. Сампайн Уламбадрах - Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, хурандаа

20. Гончигсүрэнгийн Энхбаатар - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн захирагч, хурандаа

21. Чимэддамбын Эрдэнэчулуун - Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Социологи, хүмүүнлэг судлалын төвийн дарга, дэд хурандаа

22. Цэвэгдоржийн Эрдэнээ - Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд хурандаа

## ХЕДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Лхамсүрэнгийн Амарсайхан - Батлан хамгаалах яамны Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын мэргэжилтэн, дэд хурандаа



2. Нинжбаярын Банди - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн захирагчийн орлогч, ар талын дарга, хурандаа

3. Даанжуурын Батбаатар - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа

4. Бум-Эрдэнийн Батсүх - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн цахилгаанчин ахлах ахлагч

5. Шараагийн Баяраа - Батлан хамгаалах яамны санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

6. Мөнхбаярын Баярсайхан - Батлан хамгаалахын их сургуулийн ерөнхий зориулалтын цэргийн сургуулийн ахлах багш, дэд хурандаа

7. Батцэнгэлийн Ганбаатар - Зэвсэгт хүчний 238 дугаар ангийн захирагч, хурандаа

8. Дансрангийн Гансүх - Зэвсэгт хүчний 109 дүгээр ангийн МИ-8 нисдэг тэрэгний бортмеханикч, ахмад

9. Найдангийн Гантулга - Батлан хамгаалахын их сургуулийн Ерөнхий зориулалтын цэргийн сургуулийн ахлах багш, дэд хурандаа

10. Баахүүгийн Ганхүлэг - Батлан хамгаалахын их сургуулийн хилийн цэргийн сургуулийн ахлах багш, дэд хурандаа

11. Жигжидсүрэнгийн Ганхүү - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа

12. Балдангийн Даваасүрэн - Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, хурандаа

13. Даржаагийн Дашцэрэн - Зэвсэгт хүчний 137 ангийн сургалт, соёл хүмүүжлийн албаны даргын туслах, сургалт хариуцсан офицер, хошууч

14. Ичинхорлоогийн Дулмаа - Батлан хамгаалахын их сургуулийн хүн эмнэлгийн албаны дарга, дэд хурандаа

15. Хамайны Жанайхан - Зэвсэгт хүчний галын албаны дарга, 247 дугаар ангийн захирагч, дэд хурандаа

16. Жамбалжамцын Жаргалсайхан

- Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн дайчилгаа, жагсаал анги эрхэлсэн штабын орлогч, хошууч

17. Бадамхандын Лувсан - Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн дайчилгаа, жагсаал анги эрхэлсэн штабын орлогч, хошууч

18. Раднаагийн Найдансүрэн - Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нэгдсэн удирдах байрын орлогч, байлдааны удирдлагын албаны дарга, хошууч

19. Чимэдийн Нарантуяа - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн пуужин артиллерийн зэвсэглэлийн албаны дарга, хошууч

20. Жамьяндоржийн Отгон - Батлан хамгаалах яамны төрийн захиргааны удирдлагын газрын архивын эрхлэгч

21. Жамганы Отгонбаяр - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн соёлын төвийн дарга, хошууч

22. Самдангийн Пагамсүрэн - Батлан хамгаалахын их сургуулийн туслах ажилтан-операторчин

23. Жамьянгийн Пүрэвсүрэн - Зэвсэгт хүчний 122 дугаар ангийн штабын даргын орлогч дэд хурандаа

24. Хумбагын Түмэнбаяр - Зэвсэгт хүчний 122 дугаар ангийн санхүүгийн албаны дарга, хошууч

25. Самбуугийн Үерээхүү - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн ахлах механикч, ахлах ахлагч

26. Тэрбишийн Цогтбаатар - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн сургалт, соёл хүмүүжлийн албаны дарга, дэд хурандаа

27. Гүрдоржийн Цэрэнсүх - Батлан хамгаалахын их сургуулийн Хөгжмийн сургуулийн захирал, дэд хурандаа

28. Дэнзэнгийн Чойбаатар - Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа

29. Бадарчийн Энхжаргал - Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд хурандаа

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

### Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

аймаг дахь геологи шинжилгээний "Алт" ХХК-ийн инженер-маркшейдер

5. Ахметийн Женисхан - Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн дарга

6. Төрсөлбайн Көкий - Баян-Өлгий аймаг дахь геологи, шинжилгээний "Алт" ХХК-ийн дэд захирал

7. Аукетайн Марат - Баян-Өлгий аймгийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний "Хайнар" ХХК-ийн захирал

8. Сүлеймений Минел - Ховд аймгийн Эсгий, эсгий гутлын үйлдвэрийн ерөнхий захирал

9. Халышийн Пушкий - Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Камештайн Сүйениш - Баян-Өлгий аймгийн Ахмадын хорооны дарга

2. Хурманбайн Үзбэн - Баян-Өлгий аймгийн холбооны газрын дарга

3. Бахайн Хуанбай - Баян-Өлгий аймгийн барилгын "Саулет" ХК-ийн мастер

#### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Хызырын Ануархан - Баян өлгий аймгийн Сагсай сумын Ахмадын хорооны дарга

2. Калекийн Баймурат - Баян-Өлгий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

3. Однойн Бахыт - Баян-Өлгий аймгийн Биеийн тамир, спортын хорооны бөхийн дасгалжуулагч

4. Сергалийн Жарсар - Баян-Өлгий

### ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

Хижабагийн Ыханбай - Байгаль орчны яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын орлогч дарга

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 2 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

### Төрийн ёслолын журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хавсралтын ёсоор баталсугай  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
САЙД

Р.АМАРЖАРГАЛ

Монгол Улсын Төрийн ёслолын журмыг

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД Н.ТУЯА

Засгийн Газрын 2000 оны

24 дүгээр тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЁСЛОЛЫН ЖУРАМ

Энэ журмын зорилт нь Монгол Улсын Төрийн ёслолын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, тогтсон дэг жаягийн дагуу зохион байгуулах замаар төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхэд оршино.

Төрийн ёслол гэдэг нь Монгол Улсын

үндэсний баяр ёслол, тэмдэглэлт ой, үйл явдлыг тэмдэглэх, ёслол хүндэтгэлийн бүх арга хэмжээг зохион байгуулах, төр, засгийн удирдагчдыг ёслолын арга хэмжээнд оролцуулах, тэдэнтэй уулзах гадаадын зочин төлөөлөгчдийг хүлээн авах зэрэг үйл

ажиллагааг зохицуулахдаа төрийн зүгээс баримтлах бодлогыг илэрхийлэгч хэрэгсэл мөн.

Төрийн ёслол үндэсний болон дипломат гэсэн хоёр чиглэлтэй.

### **I ХЭСЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ҮНДЭСНИЙ ЁСЛОЛ**

Төрийн үндэсний ёслол нь Монгол Улсын хэмжээнд баяр ёслол, тэмдэглэлт үйл явдлыг ёслол тэмдэглэх, төрийн тэргүүн, төрийн түшээ нар тангараг өргөж, албандаа орохоос эхлээд шинээр сонгогдож томилогдож байгаа төрийн түшээ нарт төрийн ёс жаягийг зааж сургах, эмгэнэл гашуудал илэрхийлэх хүртэл өргөн хүрээтэй үйл ажиллагааг зохион байгуулахдаа сонгодог ёс, уламжлал-заншил, шинэ хандлагыг хослуулан хэрэглэж боловсронгуй болгож байх үүрэгтэй.

### **Нэг. Баяр, тэмдэглэлт үйл явдлыг тэмдэглэх**

#### **1.1. Монгол Улсын үндэсний их баяр Наадам, Ардын хувьсгалын ой**

1.1.1. Монгол Улсын үндэсний гол баяр болох Монгол Улсын үндэсний их баяр Наадам, Ардын хувьсгалын ой (цаашид "Наадам" гэнэ)-г Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.4-т заасан өдрүүдэд тэмдэглэнэ.

*(Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиас 76.1.4. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр долдугаар сарын 11. 12. 13;)*

1.1.2. Наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан, Засгийн газрын гишүүний тэргүүлсэн комисс (цаашид "төв комисс" гэнэ) хариуцан зохион байгуулна.

1.1.3. Наадмаар зохиох гол арга хэмжээнүүд:

а) 7 дугаар сарын 10-нд Д.Сүхбаатарын хөшөөнд ёслолын журмын дагуу цэцэг өргөнө. Цэцэг өргөхөд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд (цаашид "төр, засгийн удирдагчид" гэнэ), Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Дээд шүүхийн шүүгчид, Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүд, Ерөнхий прокурор, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Ерөнхий штаб, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хилийн цэргийг удирдах газар,

нийслэлийн төр, захиргааны байгууллагын удирдлага, Улаанбаатар дахь дипломат корпусын гишүүд (хүсэлт, захиалгаар нь), УИХ-д суудалтай улс төрийн намуудын дарга, ахмадын байгууллага, иргэдийн төлөөлөгчид оролцоно. Гадаадын зочид төлөөлөгчдийг хүсэлтээр нь оролцуулна;

б) хүндэтгэлийн концерт тоглоно. Концертод төр, засгийн удирдагчид, ТӨ-П-оос ТӨ-ҮИ-д хамаарах зэрэг зиндааны албан тушаалтан нар, Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намуудын дарга, нийслэлийн иргэдийн төлөөлөгчид, төв комиссын гишүүд, Монгол Улсын генералууд, албаны бусад хүмүүс болон иргэд урилгаар оролцоно. Концерт нээхийн өмнө төрийн дуулал эгшиглэнэ.

в) тэмдэглэлт ойгоор нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн шийдвэрээр 7 дугаар сарын 11-ний өглөө Д.Сүхбаатарын талбайд цэргийн ёслолын жагсаал хийж болно. Цэргийн ёслолын жагсаалыг цэргийн дүрэмд заасны дагуу зохион байгуулна. Мөн өдрийн 22 цагт ёслолын буудлага хийнэ. Мөн баярын хурал хийнэ. Хуралд энэ зүйлийн б-д заасан хүмүүс урилгаар оролцоно. Хурлыг төв комиссын дарга удирдана. Төр, засгийн удирдах албан тушаалтан хуралд илтгэл тавина. Хурлыг нээхэд Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим төрийн дуулал эгшиглүүлэх бөгөөд хурлын дараа хүндэтгэлийн концерт тоглоно;

г) Эрийн гурван наадам явуулна. Үүнд: -7 дугаар сарын 11-нд төв цэнгэлдэх хүрээлэнд энэ журам болон төв комиссын баталсан зохиомжийн дагуу наадмын нээлтийг хийнэ;

-төв цэнгэлдэх хүрээлэнгийн төв асарт төр, засгийн удирдагчид болон ТӨ-П-оос ТӨ-ҮИ-д хамаарах албан тушаалтан нар, УИХ-д суудалтай улс төрийн намуудын дарга, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, төв комиссын нарийн бичгийн дарга, зүүн асарт Улаанбаатар дахь дипломат корпус, гадаадын зочин төлөөлөгчид, баруун асарт, ТӨ-ҮА, ТӨ-ҮИ, ТӨ-ҮИА-д хамаарах албан тушаалтан нар, төв комиссын гишүүд, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын тохируулагч агентлагийн дарга нар, ТӨ-И, ТӨ-П-т хамаарах алба хашиж явсан төрийн зүтгэлтнүүд, нийслэлийн Засаг даргын орлогчид, хотын ерөнхий менежер, аймгийн Засаг дарга, ахмадын төлөөлөгч(10 хүн) нар сууна;



-төв цэнгэлдэх хүрээлэнд төрийн далбаа мандуулсан байх бөгөөд наадмыг нээх цаг болоход Их цагаан тугийг залах ёслол эхэлнэ. Их цагаан тугийг залмагц Монгол Улсын Ерөнхийлөгч төв асраас цагаан эсгий дээгүүр залран ёслолын тавцанд гарч Их цагаан туганд ёслол наадмын ажиллагааг нээж үг хэлнэ. Үг хэлж дуусмагц нь Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим төрийн дуулал эгшиглүүлнэ. Энэ үед наадамчид суудлаасаа босч малгайгаа аван зогсоно. Ерөнхийлөгчийг төв комиссын дарга, төрийн ёслолын албаны дарга нар дагалдана;

-Ерөнхийлөгч төв асарт байраа эзлэмэгц наадмын нээлтийн арга хэмжээ зохиомжийн дагуу явагдана. Үндэсний бөхийн барилдааны нэгийн даваа эхэлнэ. Мөн спортын бусад уралдаан тэмцээн явагдана;

-төр, засгийн удирдагчид үндэсний сурын харвааны талбайд ирж сур харваж сонирхоно. Мөн хурдан морины барианы газар очиж их насны морины уралдаан үзнэ;

- 7 дугаар сарын 12-нд наадам үргэлжлэх бөгөөд төр, засгийн удирдагчид төв цэнгэлдэх хүрээлэнд хүрэлцэн очиж үндэсний бөхийн барилдаан, бусад уралдаан тэмцээн үзнэ. Ерөнхийлөгч түрүүлсэн, айрагдсан морь унасан хүүхдүүд, түрүүлсэн, үзүүлсэн бөх, түрүүлсэн мэргэн харваач нар, урьд шагнал, диплом гардуулна. Тогтсон журмын дагуу мэргэн харваач, уяач, бөхчүүдэд цол, чимэг олгоно;

-Ерөнхийлөгч наадмын ажиллагааг хааж үг хэлнэ. Их цагаан тугийг төв цэнгэлдэх хүрээлэнгээс Төрийн ордонд буцаан залах ёслол болно;

д) Монгол Улсын Ерөнхийлөгч Наадмыг тохиолдуулан 7 дугаар сарын 11-нд төрийн дайллага хийнэ. Дайллагад ТӨ-П-оос ТӨ-ҮИА-д хамаарах албан тушаалтан нар, урьд жилийн наадамд түрүүлсэн, үзүүлсэн бөх, түрүүлсэн зургаан насны морины эзэн, түрүүлсэн мэргэн харваач, ажил хэрэгч хүмүүс, иргэдийн төлөөлөгчдийг урилгаар оролцуулна, Ерөнхийлөгчөөс төрийн дайллагыг нээж үг хэлнэ. Түүний англи хэлний орчуулгыг Гадаад харилцааны яам бэлтгэж орчуулагчаар хангана;

е) Яармаг дахь уяачдын байранд уяачдад зориулсан наадам 7 дугаар сарын 13-нд болно. Урьд өдөр үдээс хойшхи уралдаанд түрүүлсэн, айрагдсан морьдын

цолыг дуудна. Шагналыг төв комиссын дарга гардуулна.

1.1.4. Наадмыг орон нутагт дараахь байдлаар тэмдэглэнэ:

а) ойд зориулан хүндэтгэлийн концерт тоглох бөгөөд концерт нээхэд төрийн дуулал эгшиглүүлнэ. Уламжлал ёсоор эрийн гурван наадам хийнэ. Орон нутгийн удирдлага хүлээн авалт хийж болно;

б) аймаг, хот, сум байгуулагдсаны тэгш ойг Наадамтай хамтатган тэмдэглэнэ. Онцгойлон үзэх шалтгаанаар өөр өдөр тэмдэглэх бол Засгийн газрын тогтоол гаргуулна.

1.1.5. Гадаадад суугаа дипломат, консулын газрууд болон олон улсын байгууллагын дэргэдэх төлөөлөгчийн газрууд Наадмыг суугаа орондоо боломжтой хэлбэрээр тэмдэглэнэ.

1.2. Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэх

1.2.1. Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг БНМАУ-ын АИХ-ын 1992 оны 1 дүгээр сарын 14-ний Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийн тухай хуулийн дагуу тэмдэглэнэ.

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ХУУЛЬ

1992 оны 1 дүгээр Улаанбаатар  
сарын 14-ний өдөр хот

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ӨДРИЙН ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэгдүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг жил бүрийн 1 дүгээр сарын 13-нд тэмдэглэж байхаар тогтоосугай.

Хоёрдугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн уг зхийг нотлох, Төрийн сүлд, далбааны зхийг залах ёслолыг 1992 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Ардын Их Хурлын танхимд зохион явуулсугай.

Дарга

Ж.УРТНАСАН

1.2.2. Монгол Улсын Ерөнхийлөгч ард түмэндээ хандаж үндэсний радио, телевизээр үг хэлнэ. Төр, засгийн удирдагчид болон төр,





засгийн удирдах албан тушаалтан нар Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөнө.Цэцэг өргөх ёслол журмын дагуу болно.

1.2.3. Тэмдэглэлт ойгоор нь онол-практикийн бага хурал хийнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч дайллаа хийж болно.

### 1.3. Бүгд найрамдах улсыг тунхагласны баярыг тэмдэглэх

1.3.1. Бүгд найрамдах улсыг тунхагласны баярыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.5-д заасан өдөр тэмдэглэнэ.

*(Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиас: 76.1.5.Бүгд Найрамдах Улс тунхагласны баяр: арван нэгдүгээр сарын 26.)*

1.3.2. Монгол Улсын Ерөнхийлөгч ард түмэндээ хандаж үндэсний радио, телевизээр үг хэлнэ.Төр, засгийн удирдагчид болон төр, засгийн удирдах албан тушаалтан нар Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөнө.Цэцэг өргөх ёслол журмын дагуу болно.

1.3.3. Тэмдэглэлт ойгоор нь нийслэл, аймгийн төвүүдэд баярын хурал хийж, хүндэтгэлийн концерт тоглоно. Монгол Улсын Ерөнхийлөгч дайллаа хийж болно.

### 1.4. Цагаан сарыг тэмдэглэх

1.4.1. Цагаан сарыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.2-т заасан өдрүүдэд тэмдэглэнэ.

*(Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиас: 76.1.2.Цагаан сар: билгийн тооллын хаврын тэрвүүн сарын шинийн 1, 2;)*

1.4.2. Монгол Улсын Ерөнхийлөгч ард түмэндээ хандаж үндэсний радио, телевизээр үг хэлнэ.

1.4.3. Битүүнд үндэсний бөхийн барилдаан зохион байгуулна.

1.4.4. Шинийн 1-нд төр, засгийн удирдагчид Гандантэгчинлэн хийдэд очиж Жанрайсиг болон монгол түмний шүтээн Очирдарь бурханд хүндэтгэл үзүүлнэ. Төр, засгийн удирдагчдад ТӨ-Ш-аас ТӨ-ҮИ-д хамаарах албан тушаалтан нар, УИХ-д суудалтай улс төрийн намуудын дарга нар Төрийн хүндэтгэлийн өргөөнд ирж золгоно. Золгохын өмнө Төрийн хан хуурыг хөглөж,

сүлд аялгууг нь эгшиглүүлнэ. .

1.4.5. Гадаад харилцааны сайд Улаанбаатар дахь гадаадын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарт зориулан цайллаа хийнэ.

### 1.5.Шинэ жилийг тэмдэглэх

1.5.1. Төр, засгийн удирдагчид Монголын хүүхдийн байгууллагаас эрхлэн зохион байгуулсан нийслэлийн хүүхдийн сүлд модны төв наадамд оролцоно.

1.5.2. Монгол Улсын Ерөнхий сайд оны шилдэг хүүхдүүдийг хүлээн авч шагнал, диплом гардуулна.

1.5.3. 12 дугаар сарын сүүлчийн ажлын өдөр Улаанбаатар дахь гадаадын дипломат төлөөлөгчийн болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газрын тэргүүн нар төр, засгийн удирдагчдад баяр хүргэнэ. Баяр хүргэхэд Гадаад харилцааны сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын гадаад харилцаа эрхэлсэн зөвлөх нар, Улсын Их Хурлын Тамгын газрын Парламент хоорондын харилцааны хэлтсийн дарга оролцоно. Дипломат корпусын ахлагч баяр хүргэж үг хэлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч хариу талархал илэрхийлнэ.

1.5.4. Ерөнхийлөгч ард түмэндээ хандаж үндэсний радио, телевизээр үг хэлнэ.

### 1.6. Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг тэмдэглэх

1.6.1. Чиглэл хариуцсан сайд үндэсний радио, телевизээр үг хэлж, ёслолын арга хэмжээ зохион байгуулна.

### 1.7. Цэргийн баярыг тэмдэглэх

1.7.1. Цэргийн баярыг жил бүрийн 3 дугаар сарын 18-нд тэмдэглэнэ.

1.7.2. Батлан хамгаалах яам, зэвсэгт хүчин, бусад цэргийн удирдлага Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөнө. Төр, засгийн удирдах албан тушаалтнууд оролцоно. Хүндэтгэлийн концерт тоглоно.

1.7.3. Тэмдэглэлт ойгоор нь төр, засгийн удирдагчид болон төр, засгийн удирдах албан тушаалтан нар Д.Сүхбаатарын



хөшөөнд цэцэг өргөнө. Цэцэг өргөх ёслол журмын дагуу болно. Баярын хурал хийх бөгөөд төр, засгийн удирдагчид оролцоно. Хурал нээхэд төрийн дуулал эгшиглэнэ.

## 1.8. Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдрийг тэмдэглэх

1.8.1. Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдрийг Монгол Улсын Их Хурлын 1996 оны 33 дугаар тогтоолд заасны дагуу тэмдэглэнэ.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 8 дугаар Дугаар 33  
Улаанбаатар  
сарын 29-ний өдөр

хот

*Хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр бий болгох тухай*

*Улс төрийн хилс хэрэгт олон мянган иргэдийг хилсээр хэлмэгдүүлсний төлөө Монголын төр ард түмнээсээ уучлал хүсэж, амь насаа алдсан хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэн мөнхжүүлэх, санан дурсах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:*

*1. Улс төрийн хэлмэгдүүлэлт өргөн хүрээтэй нийтийг хамарч өрнөсөн 1937 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөр төлөөлүүлэн жил бүрийн Есдүгээр сарын 10-ны өдрийг "Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр" болгон улс даяар тэмдэглэж байхаар тогтоосугай.*

*2. "Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр"-өөр хүндэтгэл, ёслолын арга хэмжээ зохиох, түүнд төр, засгийн байгууллага, албан тушаалтан, олон нийтийг өргөн хамруулах талаар идэвхтэй ажиллахыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, түүний харьяа орон нутгийн салбар комиссуудад даалгасугай.*

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

1.8.2. Төр, засгийн удирдагчид хэлмэгдэгсдийн дурсгалын хөшөөнд цэцэг өргөнө. Цэцэг өргөх ёслол журмын дагуу болно.

1.8.3. Сонгинохайрхан дахь хэлмэгдэгсдийн булшинд төр, засгийн удирдагчдын нэрийн өмнөөс цэцэг өргөнө. УИХ, Засгийн газрын зарим гишүүн, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон бусад яамны төлөөлөгчид, Цагаатгах ажлыг зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга нар оролцоно.

## 1.9. Эх үрсийн баярыг тэмдэглэх

1.9.1. Эх үрсийн баярыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.3-т заасан өдөр тэмдэглэнэ.

*(Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиас: 76.1.3.Эх үрсийн баяр: зургадугаар сарын 1;)*

1.9.2. Төр, засгийн удирдагчид Д.Сүхбаатарын талбайд болон бусад газарт зохиогдох баярын арга хэмжээнд оролцоно.

## 1.10. Ардчилсан хувьсгалын өдрийг тэмдэглэх

1.10.1. Ардчилсан хувьсгалын өдрийг жил бүрийн 12 дугаар сарын 10-нд тэмдэглэнэ.

1.10.2. Засгийн газрын гишүүн тэргүүлсэн комиссын баталсан төлөвлөгөөний дагуу тэмдэглэнэ. Зохион байгуулах ёслолын арга хэмжээнд төр, засгийн удирдагчид оролцоно.

## 1.11. Залуучуудын өдрийг тэмдэглэх

1.11.1. Залуучуудын өдрийг жил бүрийн 8 дугаар сарын 25-нд тэмдэглэнэ.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 8 дугаар Дугаар 29 Улаанбаатар  
сарын 23-ны өдөр хот

*"Залуучуудын өдөр" бий болгох тухай*

*Монгол орны хүн амын олонхи болсон залуучуудын асуудалд төр, олон нийтийн анхаарлыг хандуулж, залуучуудын санал санаачилгыг дэмжиж Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:*

*Жил бүрийн 8 дугаар сарын 25-ны*



өдрийг "Залуучуудын өдөр" болгон улс даяар тэмдэглэж байхаар тогтоосугай.

Хуралд Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон тангараг өргөнө.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**Нэг. Тангараг өргөх ёслолын бэлтгэл**

## 1.12. Ахмадын өдрийг тэмдэглэх

1.12.1. Ахмадын өдрийг жил бүрийн 10 дугаар сарын 1-нд тэмдэглэнэ.

## Хоёр. Тангараг өргөх

### 2.1. Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх

2.1.1. УИХ Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргасны дараа УИХ-аас товлосон өдөр, цагт Ерөнхийлөгч УИХ-д Үндсэн хуулиар тогтоосон тангараг өргөнө. Тангараг өргөх ёслол Улсын Их Хурлын 1993 оны 40 дүгээр тогтоол болон "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын 1997 оны 44 дүгээр тогтоолын дагуу явагдана.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 6 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 40 Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ДАРГА**

**Н.БАГАБАНДИ**

Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 40-р тогтоолын хавсралт

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

Монгол Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргасны дараа Ерөнхийлөгч Улсын Их Хурлаас товлон тогтоосон өдөр, цагт Монгол Улсын Их

1. Төрийн ордны их танхимын тайзны гүнд хөх цэнхэр дэвсгэр дээр Монгол Улсын төрийн сүлд залж, түүний дэргэд баруун гар талд нь Монгол Улсын төрийн далбааг байрлуулсан байна. Төрийн далбааны дэргэд ам дөрвөлжин цагаан эсгий дэвсэж, хоёр талд нь Монгол Улсын төрийн ёслолын хүндэт харуулын цэрэг зогссон байна.

Их танхимын тайзны гол хэсэгт Улсын Их Хурлын дарга, дэд дарга нарт зориулсан ширээ, сандал, түүний зүүн гар талд бүрэн эрх нь дуусгааар болж байгаа Ерөнхийлөгчид зориулсан ширээ, сандал, баруун гар талд шинэ сонгогдсон Ерөнхийлөгчид зориулсан ширээ, сандал, үг хэлэх индэр, тайзны зүүн, баруун жигүүрт Улсын Их Хурлын гишүүдийн суух сандлыг хивсэн дээр тус тус байрлуулсан байна.

2. Шинэ сонгогдсон Ерөнхийлөгчид зориулсан ширээн дээр Үндсэн хуулийн эх хувь, Ерөнхийлөгчийн тангараг бичиг, гарын үсэг зурах үзэг, бэх болон чанга яригч / микрофон/-ийг тавьсан байна.

3. Тангаргийн хавтасны гадна нүүрний дээд хэсэгт Төрийн сүлдийг алтлаг өнгөөр дүрсэлж, шил талд нь "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг" гэсэн үгийг монгол үсгээр, доод хэсэгт кирилл үсгээр тус тус дармалсан байна. Хавтасны дотор талын эхний нүүрэнд "Алтан соёмбо" үсэг зурж, нөгөө нүүрэнд Ерөнхийлөгчийн тангаргийг монгол, кирилл үсгээр гүн хөх өнгөөр гоёмсог хэвлэсэн байна.

4. Их танхимд Зэвсэгт хүчний ерөнхий штабын үлгэр жижээ үлээвэр найрал хөгжим байрласан байна.

5. Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын жиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, тусгай газрын дарга нар, Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, Ерөнхий прокурор, улс төрийн намуудын удирдагч, улсын хэмжээний зохион байгуулалтын бүтэц бүхий олон нийтийн байгууллага болон хэвлэл, мэдээллийн алба, иргэдийн төлөөлөгчид, гадаадын дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн нарыг урьсан байна.

## Хоёр. Тангараг өргөх ёслол

6. Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг мэдэгдэж Улсын Их Хурлын чуулганы хуралдааны ажиллагааг нээж "Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Их Хуралд тангараг өргөнө" хэмээн зарлан мэдэгдэнэ.

7. Ийнхүү зарламагц Ерөнхийлөгч Тамгын газрын даргаа, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч Төрийн ёслолын албаны даргыг дагуулан тангарог өргөх ёслолын танхимд хүрэлцэн ирж, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаа Ерөнхийлөгч түүнд зориулсан ширээний ард, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч өөрт нь зориулсан ширээний ард зогсоно. Ерөнхийлөгчийг дагалдан Тамгын газрын дарга төрийн ёслолын хамгаалалттайгаар Төрийн тамгыг залж авчран Ерөнхийлөгчийн өмнөх ширээн дээр тавина.

Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаа Ерөнхийлөгч, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч нар монгол үндэсний хувцастай байна.

Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааны үед Төрийн тамгыг хамгаалах үүргийг Төрийн ёслолын хүндэт харуулын дарга гүйцэтгэнэ.

Тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөхөд Төрийн тамгыг шинэ сонгогдсон Ерөнхийлөгчийг дагаж Төрийн ёслолын албаны дарга Төрийн ёслолын хамгаалалттайгаар танхимаас залж гарна. /Энэ хэсэгт Улсын Их Хурлын 1997 оны 44 дүгээр тогтоолоор орсон өөрчлөлтийг тусгав./

8. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн эх хувь дээр баруун гараа тавиад тангариийг цээжээр дээдлэн дуудаад тангарагт гарын үсгээ зурна. Дараа нь Төрийн далбааны дэргэд очиж ам дөрвөлжин цагаан эсгий дээр зүүн өөдөг сөгдөн Төрийн далбаанаас адис авна. Ийнхүү адис авсны дараа Улсын Их Хурлын даргад Ерөнхийлөгчийн тангараг бичгээ гардуулна.

9. Бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхийлөгч нь шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөсний дараа Төрийн тамгыг хадаг /нанжвандан/ дээр залж шинэ Ерөнхийлөгчид хүндэтгэлтэйгээр өргөн барина. Шинэ Ерөнхийлөгч Төрийн тамгыг

хүндэтгэлтэйгээр түшиж адислан гардаж аваад ширээн дээр зална.

10. Ерөнхийлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд шинэ сонгогдсон Ерөнхийлөгч Төрийн ёслолын албаны даргыг дагуулан тайзнаа хүрэлцэн ирж өөрт нь зориулсан ширээний ард зогсоно.

/Энэ хэсэгт Улсын Их Хурлын 1997 оны 44 дүгээр тогтоолоор орсон өөрчлөлтийг тусгав./

11. Бүрэн эрх нь хугацаанаасаа өмнө дуусгавар болсон Ерөнхийлөгчийн оронд сонгогдсон Ерөнхийлөгчид Төрийн тамгыг Улсын Их Хурлын дарга энэ журмын 9 дүгээр зүйлд заасны дагуу гардуулан өгнө.

12. Ерөнхийлөгч улиран сонгогдсон тохиолдолд Ерөнхийлөгч Тамгын газрын даргаа дагуулан Их танхимын тайзнаа хүрэлцэн ирж энэ журамд заасны дагуу тангараг өргөнө.

Ерөнхийлөгч ийнхүү хүрэлцэн ирэхдээ Төрийн тамгыг залж авчрах боловч түүнийг гардуулах ёслол үйлдэхгүй.

13. Тангараг өргөсөн Ерөнхийлөгч Төрийн тамгыг ширээн дээрээ залмагц Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчид баяр хүргэж, хөгжимд Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэнэ. Төрийн дуулал эгшиглэж байхад Их танхимд байгаа бүх хүн босож зогсоно.

14. Төрийн дуулал эгшиглэсний дараа иргэдийг төлөөлөн ахмад хүн хадаг, мөнгөн аягатай сүүг Ерөнхийлөгчид барина. Ерөнхийлөгч хадаг, мөнгөн аягатай сүүг хүлээж аваад Улсын Их Хурал болон ард түмэндээ хандаж үг хэлнэ.

Ерөнхийлөгч үг хэлж дуусмагц Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэнэ.

15. Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын ажиллагааг Монголын радио, телевизээр орон даяар нэвтрүүлнэ.

## 2.2. УИХ-ын ээлжит сонгуулийн анхдугаар чуулганыг нээх

2.2.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн товлосон өдөр Улсын Их Хурал анхдугаар чуулганаа нээнэ. Чуулганыг нээхэд Зэвсэгт



хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим төрийн дуулал эгшиглүүлнэ.

2.2.2. Улсын Их Хурлын насаар хамгийн ахмад гишүүн хуралдааныг нээж, УИХ-ын даргыг сонгох хүртэл даргална.

2.2.3. Хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын сүүлчийн дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын ерөнхий прокурор, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Улаанбаатар дахь гадаадын дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн, холбогдох бусад хүмүүс урилгаар оролцоно.

### 2.3. УИХ-ын гишүүн тангараг өргөх

2.3.1. УИХ-ын анхдугаар чуулган бүрэн эрхийг нь зөвшөөрсний дараа УИХ-ын гишүүд төрийн сүлдэнд тангараг өргөнө.

2.3.2. УИХ-ын гишүүд насаар хамгийн ахмад гишүүнээ даган уншиж тангараглана. Тангарагаа уншиж дуусаад баруун гараараа зүрхний тус газар дарж бүгд нэгэн зэрэг мэхийн ёсолно. Гишүүд тангараг өргөөд төрийн далбаанаас адис авч кирилл үсгийн цагаан толгойн дарааллаар нэрсийг жагсаасан хэвлэмэл тангарагт гарын үсэг зурж УИХ-ын гишүүний үнэмлэх, тэмдгийг гардан авна. Тангараг өргөмөгц төрийн дуулал эгшиглүүлнэ.

*Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулиас:*

#### *Нэгдүгээр бүлэг*

*4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөх*

*Улсын Их Хурлын гишүүн төрийн сүлдэндээ "Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрийн хуулийг дээдлэн сахиж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая" гэж тангараг өргөнө.*

2.3.3. Нөхөн явуулсан сонгуулийн дүнг хүчин төгөлдөр гэж үзсэн тогтоолыг баталж шинээр сонгогдсон гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсний дараа гишүүн төрийн сүлдэнд тангараг өргөнө.

Гурав. Төрийн сүлд, далбаа, туг, төрийн дуулал

3.1. Төрийн сүлд байрлуулах, төрийн далбаа мандуулах, төрийн дууллыг эгшиглүүлэх

3.1.1. Төрийн сүлд байрлуулах, төрийн далбаа мандуулах, төрийн дуулал эгшиглүүлэхдээ Монгол Улсын төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд заасан журмыг баримтална.

*Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиас*

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

*Монгол Улсын Төрийн сүлд, түүнийг үйлдэх, дүрслэх, байрлуулах*

#### *4 дүгээр зүйл. Төрийн сүлд*

*Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дууираг хөх дэвсгэртэй байна. Сүлдний төв хэсэгт Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.*

*5 дугаар зүйл. Төрийн сүлдийг үйлдэх, дүрслэх*

*1. Төрийн сүлдийг өнгө ялгах буюу ялгахгүйгээр үйлдэж дүрсэлж болно.*

*2. Төрийн сүлдийг өнгө ялган үйлдэх буюу дүрслэхэд соёмбо, эрдэнийн хүлэг, түмэн насан хээ, хүрд нь алтан шар, тэнгэр нь хөх, уулан хээ нь тодоос шингэрээж гурваар дагнасан ногоон, бадам цэцэг нь алтан шар өнгийн хүрээтэй цагаан, хадаг нь алтан шар утсаар хүрээлсэн цэнхэр, чандмань эрдэнэ нь ногоон, улаан, хөх өнгийг дөрвөөр дагнаж алтан шар өнгийн зураасаар хүрээлсэн байна. Төрийн сүлдний чандмань эрдэнэ, түмэн насан хээ, бадам цэцэг нь элгэн хүрэн*



дэвсгэр дээр байрлана.

3.Төрийн сүлдийг үйлдэх, дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран Үндсэн хуульд хавсаргасан эх загварт заасан тэг, харьцааг чанд баримтална.

6 дугаар зүйл.Төрийн сүлдийг байрлуулах

1.Төрийн сүлдийг:

1/Монгол Улсын Төрийн тамганд;

2/Монгол Улсын хилийн багананд;

3/Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын хайрцаг дээр;

4/Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэцийн хуралдааны болон Төрийн ордны соёмбот танхим, Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөө, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн даргын албан тасалгаанд;

5/иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын хуралдааны байранд-хуралдааны хугацаанд;

6/бүх шатны шүүхийн шүүх хуралдааны болон иргэдийн төрөлт, гэрлэлтийг бүртгэх танхимд;

7/бүх шатны Засаг даргын албан тасалгаанд;

8/Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Монгол Улсын яам, Засгийн газрын үндсэн бүтцэд ордог тусгай газар, иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын Тэргүүлэгчид, Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын газрын хаягт;

9/Ерөнхийлөгч, улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэц, иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн хурал, бүх шатны Засаг дарга, шүүх, прокурор, монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын газрын хэвлэмэл хуудаст;

10/галт тэрэгний зүтгүүр, суудлын вагоны хажуу талд тус тус байрлуулна.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан танхим, өргөө, албан тасалгаанд байрлуулах Төрийн сүлдийг өнгөөр ялгасан байна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад газарт Төрийн сүлдийг байрлуулах асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Монгол Улсын Төрийн далбаа, түүнийг үйлдэх, дүрслэх, мандуулах, байрлуулах

11 дүгээр зүйл.Төрийн далбаа

Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын Төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав хуваасны нэгийг хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо байрлуулна. Далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна.

12 дугаар зүйл.Төрийн далбааг үйлдэх

1.Төрийн далбааг улаан, хөх өнгийн хээгүй, цулгүй эдээр үйлдэнэ.

2.Төрийн далбааг үйлдэх, дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран Үндсэн хуульд хавсаргасан эх загварт заасан тэг, өргөн уртын 1:2-ын харьцааг чанд баримтална.

13 дугаар зүйл.Төрийн далбааг мандуулах

1.Төрийн далбааг дараахь газар байнга мандуулна:

1/Монгол Улсын Төрийн ордон;

2/Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөө;

3/аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын албан ажлын байр;

4/Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын



газрын байр.

2.Төрийн далбааг дараахь газар, тээврийн хэрэгсэл дээр түр хугацаагаар мандуулна:

1/Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн өдөр-санал хураах байр;

2/иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын хуралдааны хугацаанд-хуралдааны байр;

3/Монгол Улсын Үндсэн хуулийн болон Монгол Улсыг Бүгд Найрамдах Улсаар тунхагласан өдөр-төрийн захиргааны төв байгууллагын байр;

4/Монгол ардын хувьсгалын ойн баярын өдөр-баяр наадмын талбай, төрийн захиргааны төв байгууллага,зэвсэгт хүчин, бусад цэргийн нэгтгэл, анги болон хилийн сумангийн байр;

5/Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн болон консулын хөлөглөж яваа тээврийн хэрэгсэл;

6/хилийн асуудлаар хэлэлцээ хийхээр яваа Монгол Улсын хилийн төлөөлөгчийн хөлөглөж яваа тээврийн хэрэгсэл.

3.Төрийн далбааг Монгол Улсын бүртгэлтэй усан тээврийн хэрэгсэл дээр олон улсын нийтлэг журмыг баримтлан мандуулна.

4.Олон улсын чанартай буюу үндэсний уламжлалт биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн, наадам, тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үед олон улсын жишиг, ард түмний уламжлалыг харгалзан Төрийн далбааг өргөн мандуулж болно.

14 дүгээр зүйл.Төрийн далбааг байрлуулах, дүрслэх

1.Төрийн далбааг дараахь газар байнга байрлуулна:

1/Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүхийн шүүх хуралдааны танхим;

2/Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын

Их Хурлын дарга,Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн даргын албан тасалгаа;

3/бүх шатны Засаг даргын албан тасалгаа;

4/Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын албан тасалгаа;

5/хилийн төлөөлөгч, хилийн хороо, сумангийн даргын албан тасалгаа.

2.Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг, усан тээврийн хэрэгсэл дээр олон улсын нийтлэг журмыг баримтлан Төрийн далбааг өнгөөр ялгаж дүрсэлнэ.

15 дугаар зүйл.Төрийн далбааг бөхийлгөх, буулгах

Мандаж байгаа Төрийн далбааг орон даяар гашуудал зарласан тохиолдолд 45 хэмээр бөхийлгөх буюу ишний нь гуравны хоёрт хүртэл буулгана.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын Төрийн дуулал, түүнийг эгшиглүүлэх, хүндэтгэх

20 дугаар зүйл.Төрийн дуулал

Монгол Улсын Төрийн дуулал нь энэ хуульд хавсаргасан үг, аятай байна.

21 дүгээр зүйл.Төрийн дууллыг эгшиглүүлэх

1.Төрийн дууллыг дараахь тохиолдолд эгшиглуулна:

1/Төрийн тугийг хүндэтгэн залах ёслол үйлдэхэд;

2/Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөсний дараа;

3/Монголын ард түмний баяр ёслолд зориулсан баярын хурал, цуглаан, ёслолын ажиллагааг нээхэд;

4/Монгол Улсын түүхэнд холбогдох болон эх орон, ард түмнийхээ өмнө гарамгай гавьяа байгуулсан хүмүүсийн дурсгалд



зориулсан хөшөө, цогцолборыг нээхэд;

5/радио өргөн нэвтрүүлгийн үндсэн хөтөлбөр эхлэх, төгсөхөд;

6/бүх ард түмний баяр ёслолд зориулсан телевизийн хөтөлбөрийн анхны өдрийн нэвтрүүлэг эхлэхэд;

7/хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд.

2.Олон улсын чанартай биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн, наадам, тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үед олон улсын жишгийг баримтлан Төрийн дууллыг эгшиглүүлж болно.

3.Төрийн дууллыг найрал, үлээвэр хөгжим, дуу бичлэгийн хэрэгсэл ашиглан эгшиглүүлэх буюу найрал дуу, найрал дуу-хөгжим зэрэг бусад хэлбэрээр дуулж, хөгжимдөж болно.

4.Төрийн дууллыг энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 5-д заасан тохиолдолд бүрэн хэмжээгээр, бусад тохиолдолд эхний бадгийг дахилтын хамт эгшиглүүлнэ.

5.Цэргийн анги, нэгтгэлд Төрийн дууллыг эгшиглүүлэх журмыг цэргийн дүрмээр зохицуулна.

22 дугаар зүйл.Төрийн дууллыг хүндэтгэх

Төрийн дууллыг олон нийтийн өмнө эгшиглүүлэхэд оролцоогч бүх хүн босож хүндэтгэнэ.

### 3.2. Төрийн туг - Их цагаан тугийг хүндэтгэн дээдлэх

3.2.1. Монгол Улсын төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд заасан ёсоор төрийн туг—Их цагаан тугийг хүндэтгэн дээдэлнэ.

Монгол Улсын төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиас:

#### ГУРАВДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын Төрийн туг, түүнийг үйлдэх, байрлуулах, хүндэтгэн залах

#### 7 дугаар зүйл.Төрийн туг

1.Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн.

2.Есөн хөлт Их цагаан туг нь Монгол Улсын Төрийн туг мөн.

8 дугаар зүйл.Төрийн тугийг үйлдэх

1.Төрийн тугийг Монгол Улсын бүх аймгийн адуун сүргийн дотроос шилж сонгосон цагаан зүсмийн азарганы 80,0 см-ээс доошгүй урттай, дэл сүүлээр, ганц хувь үйлдэнэ.

2.Их цагаан тугны нийт өндөр нь ишний хамт 362,0 см, титэм /сэсэм/-ийн тойргийн голч нь 55,0 см, хөл, тугны нийт өндөр нь ишний хамт 262,0 см, титмийн тойргийн голч нь 40,0 см байна.

3.Төрийн тугны оройн хэсэгт гангаар сийлсэн, жийжүүдсэн хээтэй, сэрээ хэлбэрийн гилбэр байна. Их цагаан тугны гилбэрийн үзүүрт дээшээ дүрэлзэж байгаа галын дүрс байрлуулах бөгөөд гилбэр нь тойрсон цэцгийн дэлбээ хэлбэртэй суурь /цар/-тай байна. Уг суурь болон титмийн туурга, гилбэрийн галын дүрсийг монгол дарханы аргаар алтдаж шармалдана.

4.Төрийн туг нь шаргал хээтэй цагаан хоргойгоор хийсэн 4 хэлт манжлага бүхий бүслүүртэй байна. Бүслүүр, хэлийн уулзвар бүр дээр зэс хөөмөл дузуй толь байрлуулна.

5.Их цагаан тугны гилбэрийн өндөр 58,5 см, галын дүрсний өргөн 36,0 см, гилбэр ээсмийг холбосон 4 ширхэг ган гархины өндөр 9,5 см, өргөн 7,5 см байна. Титмийн оройд тэнцүү хэмжээтэй 8 ширхэг цэцгийн дэлбээ байна. Их цагаан тугны титмийн туурганы өндөр 10,5 см, дээд, доод хажлаганы өргөн тус бүр 1,3 см, товрууны тойргийн голч нь 3,5 см, 4 хэлт манжлаганы урт 81,0 см, манжлаганы үзүүрийн улаан хүрэн өнгийн молцогны урт 18,0 см, манжлаганы хэл тус бүрийн дээд хэсгийн өргөн 7,5 см, үзүүр хэсгийн өргөн 10,5 см, бүслүүрийн өргөн 7,5 см, манжлага бүслүүрийн хүрэн улаан өнгөт эмжээрийн өргөн 1,0 см, хэл, бүслүүрийн



уулзвар дахь зэс хөөмөл толины тойргийн голч нь 9,0 см хэмжээтэй байна.

6. Хөл тугны гилбэрийн өндөр 31,0 см, титмийн туурганы өндөр 9,0 см, дээд, доод хажлаганы өргөн тус бүр 1,0 см, товрууны тойргийн голч нь 2,5 см, 4 хэлт манжлаганы урт 61,0 см, манжлаганы хэл тус бүрийн дээд хэсгийн өргөн 6,5 см, үзүүр хэсгийн өргөн 9,5 см, бүслүүрийн өргөн 7,0 см, манжлага, бүслүүрийн хүрэн улаан өнгөт эмжээрийн өргөн 0,5 см, хэл, бүслүүрийн уулзвар дахь зэс хөөмөл толины тойргийн голч нь 7,0 см хэмжээтэй байна.

7. Төрийн тугны ишийг хус модыг хатааж, тосонд чанаж өнгөлж хийнэ. Их цагаан тугны ишний өндөр нь 303,5 см, голч нь 5,0 см, хөл тугны ишний өндөр нь 231,0 см, голч нь 3,5 см хэмжээтэй байна.

8. Энэ хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Төрийн тугийг дуурайлган үйлдэхийг хориглоно.

9 дүгээр зүйл. Төрийн тугийг байрлуулах

1. Төрийн тугийг өнгийн чулуу шигтгэж, дотор нь Монгол Улсын бүх аймгийн хөрсний дээжийг байрлуулсан цутгасан, шаталсан хэлбэртэй хот, улсыг бэлгэдсэн хүрээ мандалын байдалтай суурь дээр залж Төрийн ордонд байрлуулна.

2. Төрийн тугийг газарт хүргэхийг цээрлэнэ.

10 дугаар зүйл. Төрийн тугийг хүндэтгэн залах

1. Монгол ардын хувьсгалын ойн баярын өдөр баяр наадмын Төв талбайд Төрийн тугийг хүндэтгэн зална.

2. Төрийн тугийг хүндэтгэн залах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

3.2.2. Их цагаан тугийг залах ёслол "Төрийн тугийг хүндэтгэн залах журам батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 67 дугаар зарлигийн дагуу явагдана.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 6 дугаар Дугаар 67 Улаанбаатар сарын 30-ны өдөр хот

## ТӨРИЙН ТУГИЙГ ХҮНДЭТГЭН ЗАЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

1. "Төрийн бэлгэ тэмдгийн тухай" Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн "Монгол Улсын Төрийн тугийг хүндэтгэн залах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ зарлигийг 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын  
Ерөнхийлөгч

П.ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн

1994 оны 67 дугаар зарлигийн 1 хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ТУГИЙГ ХҮНДЭТГЭН ЗАЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Төрийн бэлгэ тэмдгийн хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу Монгол ардын хувьсгалын ойн баярын өдөр Төрийн тугийг баяр наадмын төв талбайд хүндэтгэн залахад энэ журмыг баримтална.

2. Төрийн тугийг хүндэтгэн залах ажиллагааг төрийн хонжин, тэргүүн тугч, тугчид гүйцэтгэх бөгөөд төрийн ёслолын торгон цэрэг хамгаална. Төрийн тугийг хүндэтгэн залах үед Төрийн хонжин энэ ажиллагаанд оролцож байгаа төрийн ёслолын торгон цэргийг захирна. Бүгд 32 морьтон оролцоно.

3. Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга Төрийн хонжин, тэргүүн тугч, тугчдыг томилно.

4. Төрийн тугийг хүндэтгэн залахад хонжин эхэнд нь, дараа нь тэргүүн тугч, тугчид гурван эгнээгээр, удаах нь торгон цэргийн захирагч, түүний орлогч, торгон цэргүүд дөрвөн эгнээгээр цуван жагсаж явна.

5. Хонжин, тэргүүн тугч, тугчид зэрэг дэвээрээ ёслолын хувцастай, тэргүүн тугч, тугчид хуяг дуулгатай, хонжин, тэргүүн тугч цагаан зүсмийн азарга, тугчид шарга зүсмийн морь унасан байна.

Торгон цэргийн захирагч, түүний орлогч хар, цэргүүд хар, хээр, хүрэн зүсмийн

морь унаж торгон цэргийн дүрэмт хувцастай эзлэм зүүсэн байна.

Хоёр. Төрийн тугийг Төрийн ордноос баяр наадмын төв талбайд хүндэтгэн залах

6. Төрийн тугийг хүндэтгэн залах 32 морьтон Төрийн ордны зүүн өмнө жигүүрийн дэргэд ирээд хонжин "Мориноосоо" гээд буухад тэргүүн тугч, тугчид, торгон цэргийн захирагч, түүний орлогч, торгон цэргийн 2, 4 дүгээр цувааны цэргүүд мориноосоо нэгэн зэрэг бууна. Мориноосоо буусан торгон цэргүүд зүүн гартаа зэрэгцэж яваа 1, 3 дугаар цувааны цэрэгт мориныхоо цулбуурыг шилжүүлэн өгөөд хонжин, тэргүүн тугч, тугчдын морины цулбуурыг авч морь баригчийн үүрэг биелүүлнэ.

7. Хонжин "Тугчид миний хойноос" гээд өөрөө тэргүүлж тэргүүн тугч гурваар эгнэн жагссан тугчдийг дагуулж Төрийн ордны хүндэтгэлийн хаалга, Төрийн тугийн байранд нэгийн цуваагаар орж, хонжин үүдэн тус газар, тэргүүн тугч, тугчид Төрийн тугийг нар зөв тойрон тэргүүн тугч Их цагаан тугны дэргэд, тугчид оноот хөл тугны дэргэд байраа тус тус эзлэнэ.

Тугчид Төрийн ордонд орж ирэхэд Төрийн ордны хамгаалалтын тусгай тасгийн дарга угтана.

8. Хонжин, тэргүүн тугч, тугчид гурвантаа мэхийн ёсолсны дараа тугчид оноот хөл тугаа түшиж Их цагаан туганд мэхийлгэхэд тэргүүн тугч Их цагаан тугийг өргөж хонжинг чиглэн явахад тугчид зүүн жигүүрээсээ эхлэн нар зөв эргэж явна.

9. Хонжин манлайлан тэргүүн тугч, тугчид дэслэн Төрийн тугийн байрнаас гарч гурваар эгнэн зогсоно. Хонжин "Тугчид миний хойноос" гээд Төрийн хүндэтгэлийн хаалгаар гарахад тугчид гурван эгнээгээр жагсан явж торгон цэргийн жагсаал руу очно.

10. Хонжин "Мориндоо" гэхэд тугчид мордож эмээлийн урд бүүрэгэнд бэхэлсэн сууринд тугаа суурилуулна. Морийг нь барьж байгаа торгон цэргүүд тэдэнд тусалж жолоо, цулбуурыг өгөөд цуваагаар явж мориндоо мордоно. Хонжин манлайлан Төрийн ордныг нар зөв тойрон баяр наадмын төв талбай руу ергүүлэн орно.

11. Төрийн тугийг баяр наадмын төв

талбайн зүүн урд жигүүрээр залан орж ирэхэд наадамчид суудлаасаа босож хурайлж мэхийн ёсолж өнгөрөөнө. Хонжин, Тэргүүн тугч, тугчид нар зөв тойрон тугийн суурь хүртэл дэвссэн цагаан эсгийний баруун захаар цуван, торгон цэрэг тус тусын тогтоосон газарт зогсоно.

12. Хонжин "Мориноосоо" гэхэд торгон цэргийн захирагч, түүний орлогч, 2, 4 дүгээр цувааны цэргүүд мориноосоо нэгэн зэрэг бууж зүүн гартаа зэрэгцэн яваа 1, 3 дугаар цувааны цэрэгт цулбуураа шилжүүлэн өгч, нэгийн цуваагаар эсгий дээгүүр алхалж хонжин, тэргүүн тугч, тугчдын дэргэд хүрч зогсон баруун тийш эргэн морьдын цулбуурыг авч мориноос нь түшиж эсгий дээр буулгана. Хонжин "миний хойноос" гэхэд тэргүүн тугч, тугчид тугаа өргөж, хонжинг даган тугны суурь хүрч нар зөв тойрон тус тусын байранд очиж нэгэн зэрэг баруун тийш эргэнэ. Хонжин суурь өөд харж зогссон байна. Энэ үед тугийн харуул ирж суурийн дөрвөн талд зогссон байна.

13. Хонжин "Их цагаан тугийг мандуул" гэхэд тэргүүн тугч суурийн урд байрлуулсан шатаар өгсөн Их цагаан тугийг зална. Тэргүүн тугч буумагц шатыг сууринаас холдуулна. Хонжин "хөл тугийг чагтал" гэхэд тугчид урагш алхаж хөл тугийг байрлуулна. Энэ үед төрийн их хэнгэрэг дэлдэж, харанга цохиж, хашгираа ихт бүрээ татна.

14. Тэргүүн тугч, тугчид баруун тийш зэрэг эргэж, тогтоосон дарааллаар явж, торгон цэрэг жагсаалдаа хүрч мориндоо мордоцгооно. Хонжингийн морийг хөтөлсөн торгон цэргийн захирагч "алхуул" гэхэд нар зөв эргэн баяр наадмын төв талбайн баруун жигүүрээр гарч орно.

15. Төрийн тугийг баяр наадмын төв талбайд хүндэтгэн залсан үед шөнийн цагт солбисон гэрлээр гэрэлтүүлэн төрийн ёслолын торгон цэрэг хамгаална.

Гурав. Төрийн тугийг баяр наадмын төв талбайгаас Төрийн ордонд хүндэтгэн залах

16. Монгол Улсын Ерөнхийлөгч баяр наадмын ажиллагааг хааж үг хэлсний дараа Төрийн тугийг баяр наадмын төв талбайгаас Төрийн ордонд хүндэтгэн зална. Баяр наадмын төв талбайн зүүн урд жигүүрээр хонжин, тэргүүн тугч, тугчид, торгон цэрэг ергүүлэн орж ирж нар зөв тойрон тус тусын

байранд зогсоно. Хонжин "мориноосоо" гэхэд тэргүүн тугч, тугчид болон торгон цэргийн захирагч, түүний орлогч, 2, 4 дүгээр цувааны цэрэг нэгэн зэрэг мориноос бууж хонжин, тэргүүн тугч, тугчдын морийг барина.

17. Тугчид хонжингийн дохиогоор туг руу очиж оноот тугаа харж зогсоно. Хонжин "хөл тугийг түш" гэхэд тугчид урагш алхан шинээс нь барин тугийг түшиж сууринаас нь өргөн авч Их цагаан туганд мэхийлгэнэ. Хонжин "Их цагаан тугийг түш" гэхэд тэргүүн тугч шатаар гарч Их цагаан тугийг өргөн бууж суурийн өмнө талд зогсоно. Хонжин "мориндоо" гэхэд тугчид мордож эмээлийн урд бүүргэнд бэхэлсэн сууринд тугаа суурилуулна. Морийг нь барьж байгаа торгон цэргүүд тэдэнд тусалж жолоо, цулбуурыг нь өгөөд цуваагаар яаж мориндоо мордоно.

Хонжин "алхуул" гэхэд нар зөв эргэж төв асрын өмнүүр яаж баяр наадмын төв талбайн баруун жигүүрээр гарч одно. Энэ үед наадамчид босч хурайлан, төрийн их хэнгэрэг, харанга дэлдэж, хашгираа ихт бүрээ татаж үлээнэ.

18. Төрийн тугийг залж Төрийн ордны баруун өмнө жигүүрт ирэхэд Төрийн ордны хамгаалалтын тусгай тасгийн дарга угтана. Хонжин "мориноосоо" гэхэд торгон цэрэг буун хонжин, тугчдыг түшиж буулган, морьдыг нь барьж зогсоно. Хонжин "алхаад" гэхэд тэргүүн тугч, тугчдыг Төрийн ордны хүндэтгэлийн хаалгаар дагуулан орж, Төрийн тугийн байр руу очно. Хонжин "Их цагаан тугийг зал" гэхэд тэргүүн тугч Их цагаан тугийг сууринд нь зална. Хонжин "хөл тугийг чагтал" гэхэд тугчид тогтоосон дарааллаар тугийн байранд орж, хөл тугийг нэгэн зэрэг байрлуулна. Хонжин, тэргүүн тугч, тугчид Их цагаан туганд ёслоод Төрийн тугийн байрнаас гарна.

### **Дөрөв. Тамга шилжүүлэх**

4.1.1. УИХ-ын сонгуулийн анхдугаар чуулган дээр УИХ-ын дарга сонгогдмогц УИХ-ын тамга шилжүүлэх ёслол болно. Шинээр сонгогдсон УИХ-ын дарга УИХ-ын тамгыг гардаж адис аваад УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргад шилжүүлэн хадгалуулна.

4.1.2. УИХ-ын дарга УИХ-д хандаж үг хэлнэ.

4.2.1. Ерөнхий сайд томилогдмогц Засгийн газрын тамгыг шилжүүлэх ёслол "Соёмбо" танхимд болно. Ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч оролцоно. Түрүүчийн Засгийн газрын гишүүд танхимд жагсан зогссон байна.

4.2.2. Ерөнхийлөгч шинээр томилогдсон Ерөнхий сайдыг дагуулан танхимд орж ирж зогсоход өмнөх Ерөнхий сайд Засгийн газрын тамгыг шинээр томилогдсон Ерөнхий сайдад гардуулан өгнө. Ерөнхий сайд тамгыг гардаж адис аваад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад хадгалуулна.

4.2.3. Өмнөх Ерөнхий сайд шинээр томилогдсон Ерөнхий сайдад хадаг, мөнгөн аягатай сүү барина. Ерөнхий сайд талархал илэрхийлнэ.

4.3.1. УИХ-ын дарга дахин сонгогдох, Ерөнхий сайд улиран томилогдох тохиолдолд тамга шилжүүлэх ёслол үйлдэхгүй.

### **Тав. Төр, засгийн шагнал гардуулах**

5.1. Дээд шагнал гардуулах

5.1.1. Төрийн шагнал хүртээх ёслол Төрийн хүндэтгэлийн өргөөнд болно.

5.1.2. Шагнал хүртэгсэд өргөөний баруун талд зогссон байна. Ёслол эхлэх цаг болоход Монгол Улсын Ерөнхийлөгч хүрэлцэн ирж шагнал хүртэгсэдтэй мэндлээд өргөөний хойморт байраа эзэлнэ. Шагнал гардуулахад чиглэл хариуцсан сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга байлцана.

5.1.3. Шагнах тухай Ерөнхийлөгчийн зарлигийг уншихад Ерөнхийлөгч шагналын тэмдгийг зүүж, үнэмлэхийг гардуулж өгнө. Шагнал хүртэгсдийн төлөөлөгч талархал илэрхийлж хариу үг хэлж болно.

5.2.1. Монгол Улсын Засгийн газрын "Хүндэт өргөмжлөл" шагнал гардуулах ёслолыг улсын болон хөдөлмөрийн баатар цол олгох, төрийн шагнал хүртээх ёслолын жишгээр гүйцэтгэнэ. Ерөнхий сайд цол, шагналыг олгож, Засгийн газрын гишүүн, Хэрэг эрхлэх газрын дарга нар байлцана.

5.3.1. Монгол Улсын одон, медаль гардуулах ёслол төрийн ордны "Соёмбо"

танхимд болно. Ерөнхийлөгч одон медалийг гардуулна.

5.3.2. Шагнал гардуулах ёслол цол, шагнал хүртээх ёслолтой адил байна.

5.4.1. Ерөнхийлөгч болон Засгийн газрын даалгавраар төр, засгийн удирдах албан тушаалтан нийслэл болон аймаг, орон нутагт шагнал гардуулж болно.

## **Зургаа. Төр, засгийн удирдагчид орон нутагт**

6.1. Төр засгийн удирдагчид, төр, засгийн удирдах албан тушаалтан нарыг орон нутагт явахад үдэх, угтах

6.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Төрийн ёслолын албаны дарга, УИХ-ын даргыг УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга, Төрийн ёслолын албаны дарга, Ерөнхий сайдыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн ёслолын албаны дарга, УИХ-ын дэд даргыг УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Төрийн ёслолын албаны ажилтан, бусад албан тушаалтныг тухайн байгууллагын аппаратын ажилтан үдэж, угтана.

6.1.2. Төр, засгийн удирдагчид аймаг, сумын төвд хүрэлцэн очиход аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга нар Тамгын газрынхаа даргын хамт угтаж, үднэ.

6.2. Төр, засгийн удирдагчид болон төр, засгийн удирдах албан тушаалтан нарыг орон нутагт хүлээн авах

6.2.1. Төр, засгийн удирдагчид сонгогдож, томилогдсоныхоо дараа анх удаа аймаг, орон нутагт очиход аймгийн төвд хүндэтгэн угтах ёслол болно. Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга нар, хөдөлмөрчдийн төлөөлөгчид угтана. Аймгийн Засаг дарга хадаг, аягатай сүү барина. Аймгийн нутгаар аймгийн Засаг дарга, аюулаас хамгаалах албаны төлөөлөгч, цагдаагийн газрын дарга дагалдан явна.

6.2.2. УИХ-ын дэд даргыг аймаг, орон нутагт ажиллахад аймаг, сумын нутгаар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга буюу Засаг даргын орлогч дагалдан явна.

## **Долоо. Уулзалт, арга хэмжээ, бэлэг дурсгал**

7.1. Төр, засгийн удирдагчид болон төр, засгийн удирдах албан тушаалтан гадаадын зочид, төлөөлөгчидтэй уулзах

7.1.1. Төр, засгийн удирдагчид, төр, засгийн удирдах албан тушаалтан нарыг гадаадын албан ёсны зочин, төлөөлөгчидтэй уулзуулах асуудлыг зөвхөн Төрийн ёслолын алба буюу ГХЯ-ны Ёслолын хэлтсээр дамжуулан шийдвэрлэж байна.

7.1.2. Төр, засгийн удирдагчид болон төр, засгийн удирдах албан тушаалтан нар тус улсад суугаа гадаадын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, гишүүдтэй харилцах асуудлыг ГХЯ-ны Ёслолын хэлтэс эрхлэн гүйцэтгэнэ.

7.1.3. Төр, засгийн удирдагчид болон төр, засгийн удирдах албан тушаалтантай гадаадын үйлдвэр, худалдаа, нам болон төрийн бус байгууллагуудын шугамаар ирсэн зочин, төлөөлөгчдийг уулзуулах асуудлыг Төрийн ёслолын албаар дамжуулан шийдвэрлэж байна. Тухайн зочин, төлөөлөгчдийг урьж ирүүлсэн байгууллага, хүмүүс зочид, төлөөлөгчдийн ирсэн зорилго, тэдгээрийн талаархи товч танилцуулга, Монголд хүлээн авах байгууллага болон хүмүүс, байх хугацаа, зардлын талаар 7 хоногийн өмнө бичгээр Төрийн ёслолын албанд мэдэгдсэн байна. Төрийн ёслолын алба нь уулзуулах эсэх асуудал болон түвшингийн талаар ГХЯ-тай зөвшилцөн шийдвэрлэнэ.

7.1.4. Төр, засгийн удирдагчид болон төр, засгийн удирдах албан тушаалтантай гадаадын дээд, өндөр хэмжээний төлөөлөгчид болон дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн нарыг уулзахад байх хүмүүс болон орчуулагч, тэмдэглэл хөтлөх буюу хэвлэл



мэдээллийн албаны ажилтнуудыг ГХЯ-ны Ёслолын хэлтэс зохицуулах бөгөөд Төрийн ёслолын албатай ажлаа уялдуулсан байна.

7.1.5. Төрийн ёслолын алба Төрийн ордонд болох уулзалтын цаг, байр, үйлчилгээг зохицуулан холбогдох албадад мэдээлэх, зочдыг угтах, үдэх ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

7.1.6. Төрийн ордны хамгаалалтын алба Төрийн ёслолын алба болон ГХЯ-ны Ёслолын хэлтэсээр дамжуулан уулзалтаа тохироогүй гадаадын зочин, төлөөлөгч, иргэдийг Төрийн ордонд нэвтрүүлэхгүй байна.

7.1.7. Төр, засгийн дээд хэмжээний айлчлалаас бусад тохиолдолд төр, засгийн удирдагчид гадаадын зочин, төлөөлөгчдийг хүлээн авч уулзах үед болон ёслолын үйл ажиллагаанд зөвхөн Төрийн ёслолын албаны зурагчин үйлчилнэ.

7.1.8. Төрийн ёслолын алба төрийн ёслолын үйл ажиллагаа болон төр, засгийн удирдагчдын уулзалтыг гэрэл зургаар баримтжуулж жил бүр архивт шилжүүлэх ажлыг хариуцна.

7.1.9. Төр, засгийн удирдагчид гадаадын зочин, төлөөлөгч хүлээн авч уулзахад албан ёсны орчуулагч болон тэмдэглэл хөтлөх ажилтанг байлцуулна. Уулзалт, ярианы тэмдэглэлийг төр, засгийн удирдагчдад 3 хоногийн дотор танилцуулж холбогдох газруудад шилжүүлэн өгч байна.

7.1.10. Төр, засгийн удирдагчид болон төр, засгийн удирдах албан тушаалтан нар гадаадын төр, засгийн өндөр албаны хүмүүстэй утсаар ярихдаа тэмдэглэл хөтөлж, тэмдэглэлийн хувийг ГХЯ-нд өгч байна.

7.1.11. Төр, засгийн удирдагчид гадаадын зочин, төлөөлөгчдийг хүлээн авч уулзахад оролцох хүмүүсийн тооны хязгаарыг Төрийн ёслолын алба, ГХЯ-ны Ёслолын хэлтэс тогтооно.

7.1.12. Төр, засгийн удирдагчдаас ярилцлага авах асуудлыг тэдгээрийн хэвлэл мэдээллийн албад, ГХЯ-ны Мэдээлэл,

мониторингийн газар хариуцан зохицуулна.

**7. . Төр, засгийн удирдагчид болон төр, засгийн удирдах албан тушаалтан ёслолын арга хэмжээнд оролцохыг зохион байгуулах**

7.2.1. Төр, засгийн удирдагчдыг ёслолын арга хэмжээнд урьсан бүх урилгыг Төрийн ёслолын албаар дамжуулна. Төрийн ёслолын алба тухайн арга хэмжээнд хэрхэн оролцуулах саналаа төр, засгийн удирдагчдад танилцуулж шийдвэрлэнэ.

7.2.2. Төрийн ёслолын алба УИХ-ын дэд дарга, УИХ болон Засгийн газрын гишүүдийг урьсан урилгыг хүлээн авч зохицуулан өөрсдөд нь мэдэгдэж байна.

7.2.3. Улаанбаатар дахь гадаадын дипломат корпусаас зохиох арга хэмжээг ГХЯ-аар уламжлан урьдчилан тохиролцсоны үндсэн дээр товлон. Төрийн ёслолын алба ГХЯ-ны саналыг үндэслэн тухайн арга хэмжээнд ямар түвшинд оролцуулахыг шийдвэрлэнэ.

7.2.4. Төр, засгийн удирдах албан тушаалтан ёслолын арга хэмжээ, уулзалтын үеэр дипломат корпусын зүгээс аман урилга авбал дараа нь ёслолын албадаар дамжуулан албан ёсоор тохирох тухайгаа мэдэгдэж байна.

7.2.5. Төрийн ёслолын алба УИХ-ын болон Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шугамаар буюу Төрийн ордонд болох ёслолын бүх арга хэмжээг эрхлэн зохион байгуулна.

**7.3. Бэлэг дурсгалын зүйл хүлээн авах, өгөх**

7.3.1. Төр, засгийн удирдагчид, төр, засгийн удирдах албан тушаалтан бэлэг дурсгалын зүйл хүлээн авах, өгөх асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын заалтыг үндэслэн шийдвэрлэж байна.

*Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын II хавсралт*



## **БЭЛЭГ ДУРСГАЛЫН ЗҮЙЛ ГАРДУУЛАХ, ХҮЛЭЭН АВАХ, ТАЙЛАГНАХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Ерөнхий зүйл**

1. Монгол Улсын төр, засгийн удирдагчид, Засгийн газрын гишүүд болон Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээртэй адилтгах албан тушаалтнаас гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд бэлэг, дурсгалын зүйл гардуулах, илгээх, хүлээн авах, тэдгээрийг зарцуулах, тайлагнах үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

### **Хоёр. Бэлэг, дурсгалын зүйл гардуулах**

2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй тэдгээртэй адилтгах зиндааны гадаадын зочин, төлөөлөгчдөд өгөх бэлэг, дурсгалын зүйлийг баталсан төсвийн дагуу Төрийн ёслолын албаны бэлэг дурсгалын сангаас бүртгэл, тайланд тусган гаргаж зочны байранд хүргэж өгнө.

3. Дээрх албан тушаалтан албан ёсны айлчлалаас бусад үед гадаад дотоодын зочин, төлөөлөгчдөд гарын бэлэг, дурсгалын зүйл гардуулах, илгээхэд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 100,0 мянган төгрөг, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас 80,0 мянган төгрөгөөс тус тус илүүгүй үнэтэй зүйл нэг хүнд ноогдохоор тооцож Төрийн ёслолын алба бэлэг дурсгалын сангаас бүртгэл, тайланд тусган гаргаж өгнө.

4. Монгол Улсын Гадаад харилцааны сайдаас гадаадын зочин, төлөөлөгчдөд нэг хүнд 65,0 мянган төгрөг, Монгол Улсын сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээртэй адилтгах албан тушаалтнаас тухайн салбар, чиглэлийн шугамаар албан ёсны айлчлал хийж буй ижил зиндааны гадаадын зочин, төлөөлөгчдөд нэг хүнд 50,0 мянган төгрөг, албан айлчлалын бус үеийн гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд нэг

хүнд 40,0 мянган төгрөгөөс тус тус илүүгүй үнэтэй зүйл байхаар тооцож уг яам, байгууллагын байрны захиргаа буюу санхүү, аж ахуй хариуцсан алба бүртгэл тайланд тусган гаргаж өгөх ажлыг зохион байгуулна.

5. Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагаас гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд гардуулах бэлэг, дурсгалын зүйлийг нэг хүнд 40,0 мянган төгрөгөөс илүүгүй үнэтэй байхаар тооцож Төрийн ёслолын алба бэлэг дурсгалын сангаас бүртгэн гаргаж олгоно.

6. Зочин, төлөөлөгчдөд өгөх бэлэг, дурсгалын зүйлс нь соёлын чанартай зүйл байх бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон түүх, дурсгалын үнэт эдлэл, байгалийн үнэт эрдэнэс баялгийн болон бусад зүйл байж үл болно.

7. Монгол үндэсний дээл, малгайг Монгол Улсад анх удаа айлчилж буй гадаад улсын төр, засгийн тэргүүн, тэдний гэргий (нөхөр)-д айлчлалын үеийн төсөвт тусган бэлэглэж болно.

8. Зочин, төлөөлөгчдийн очсон байгууллага бүр бэлэг өгөх шаардлагагүй, харин өөрийн танилцуулга, зурагт хуудас, энгэрийн тэмдэг дурсгаж болно.

Бэлгийн зүйлийг тэдгээрийг урьсан байгууллага хариуцна.

9. Дээр дурдсан албан тушаалтнууд гадаад улсад айлчлах, дотоодод томилолтоор ажиллахад шаардагдах бэлэг, дурсгалын зүйлийн хэмжээг энэ бүлэгт заасны нэгэн адил мөрдөнө.

Гурав. Бэлэг, дурсгалын зүйл хүлээн авах, тайлагнах, зарцуулах

10. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага гадаад, дотоодын зочин, төлөөлөгч, байгууллага, иргэдээс

албан үүрэгтэй нь холбогдуулан өгсөн бэлэг, дурсгалын зүйлсийг Төрийн ёслолын албаар дамжуулан авна. Төрийн ёслолын алба бэлэг, дурсгалын зүйлийг үнэлүүлэн бүртгэлд тусгаж уг зүйл тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас илүүгүй үнэтэй бол эзэнд нь шууд дамжуулна. Хэрэв тухайн албан тушаалтан бэлэг, дурсгалын зүйлийг үнэ харгалзахгүйгээр бэлгийн санд шилжүүлэхийг хүсвэл уг зүйлийг зохих журмын дагуу үнэлүүлэн бүртгэж авна.

11. Тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас илүү үнэтэй бол Төрийн ёслолын алба дор дурдсан зарчмыг баримтлан шийдвэрлэнэ.

а/ бэлгийн зүйлийг үнээр нь үнэлэн бэлгийн санд орлого болгох;

б/ тухайн албан тушаалтан бэлэг, дурсгалын зүйлээ хувьдаа авах хүсэлт тавьсан тохиолдолд түүний нэг сарын цалингийн хэмжээнээс илүү гарах зөрүүг өөрөөс нь гаргуулан Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын санхүүд шилжүүлж, уг бэлэг, дурсгалын зүйлийг өөрт нь олгох;

в/ зочин, төлөөлөгч, байгууллага, иргэдээс өгсөн бэлэг, дурсгалын зүйл нь түүх, соёл, улагийн дурсгалт зүйл, эрдэнэсийн сан хөмрөгт орох эдлэл буюу гадаад харилцааны түүхэнд холбогдох ховор эд материалд хамаарах зүйл байвал үнэ харгалзахгүйгээр бэлгийн санд тодорхой бүртгэн авч, шаардлагатай эд зүйлсийг зохих журмын дагуу үндэсний музей болон холбогдох бусад байгууллагад албан баримтаар шилжүүлэх;

12. Дээрх албан тушаалтнуудаас бэлгийн санд бэлэг, дурсгалын зүйлийг хүлээж авсан болон хүлээлгэн өгсөн тухай актыг хоёр хувь үйлдэнэ. Уг актын нэг хувь тухайн албан тушаалтанд, үлдэх хувийг Төрийн ёслолын албаны бэлгийн сан хариуцсан ажилтан хадгалан Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газарт улирал бүр тайлан гаргаж өгнө. Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар нь дээрх тайланг хагас жил тутам Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг

эрхлэх газарт мэдээлж байна.

13. Бэлгийн санд орлого болгосон эд зүйлийг Төрийн ёслолын албанаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшилцөн зориулалтын дагуу ашиглан зарцуулна.

14. Монгол Улсын сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээртэй адилтгах албан тушаалтан зочин, төлөөлөгч, байгууллага, иргэдээс албан үйл ажиллагаатай нь холбогдуулан өгсөн бэлэг, дурсгалын зүйлийг хүлээн авах, тайлагнах, зарцуулах ажиллагааг энэ бүлэгт заасан журмын дагуу холбогдох алба, албан тушаалтнуудаар нэгэн адил гүйцэтгүүлнэ.

#### Дөрөв. Бусад зүйл

15. Энэ журамд зааснаас бусад албан тушаалтан, ажилтан нараас албан ажлын шугамаар гадаад, дотоодын зочин, төлөөлөгч, байгууллага, иргэдэд бэлэг, дурсгалын зүйл гардуулах шаардлагатай бол тухайн байгууллагын удирдлагаас тусад нь төсөв батлуулан хэрэгжүүлж болно.

16. Дээрх албан тушаалтан, ажилтан нарт албан ажлынх нь чиг үүрэгтэй холбогдуулан зочин, төлөөлөгч, байгууллага, иргэдээс өгсөн бэлэг, дурсгалын зүйлийг мөн энэ журамд заасныг мөрдлөг болгон шийдвэрлэнэ.

#### Найм. Цэцэг өргөх

##### 8.1. Д.Сүхбаатарын хөшөөнд

8.1.1. Хөшөөний урд талд төрийн хүндэт харуул, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим хөшөө рүү харан жагсана, хөшөөний зүүн талаас хөшөө хүртэл цэцэг өргөх замын турш гудаслаг нарийн хивс, цэцэг өргөх газарт том хивс тус тус дэвсэж хивсний үзүүр талд цэцгийг өргөх дарааллаар байрлуулна,

8.1.2. Цэцэг өргөх цаг болоход найрал

хөгжим "Шивээ хиагт" аяыг эгшиглүүлж цэцэг өргөх ёслол эхэлнэ, хүндэт харуулын цэргүүд цэцгийг хос хосоороо барьж хүндэтгэлийн алхаагаар явж дэвссэн хивсэн дээр дарааллын дагуу баруун, зүүн тал руу нь ээлжлүүлэн байрлуулна, цэцэг өргөгсөд цэцгийн өмнө мэхийн ёслоод хөшөөг нар зөв тойрч хөшөөний зүүн талд гаран цэцэг өргөсөн дарааллаар төрийн хүндэт харуул руу харж цуван зогсоно.

8.1.3. Цэцэг өргөж дуусахад төрийн дуулал, цэцэг өргөгсөд тарж явахад баярын марш эгшиглүүлнэ.

## **8.2. Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нарын бунханд**

8.2.1. Төрийн хүндэт харуул, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим бунхны баруун талд жагсана, бунхны үүд рүү гудаслаг нарийн хивс дэвсэж хивсний үзүүрээс эхлэн цэцгийг өргөх дарааллаар байрлуулна.

8.2.2. Цэцэг өргөх цаг болоход найрал хөгжим "Шивээ хиагт" аяыг эгшиглүүлж ёслол эхэлнэ. Хүндэт харуулын цэргүүд цэцгийг хос хосоороо барьж хүндэтгэлийн алхаагаар явж шарилын толгой талд дараалуулан байрлуулна. Цэцэг өргөгсөд нэг минут орчим толгой гудайн зогсож хүндэтгэл илэрхийлээд зүүн талын хаалгаар гарч, бунхны зүүн урд талд байраа эзлэн зогсоно.

8.2.3. Цэцэг өргөж дуусахад хөгжимд төрийн дуулал эгшиглүүлнэ. Гадаадын зочин, төлөөлөгчид цэцэг өргөхөд тухайн орны болон Монгол Улсын төрийн дууллыг эгшиглүүлнэ.

## **8.3. Зайсан толгой дахь дурсгалын хөшөөнд**

8.3.1. Хөшөөний өмнөх талбайн баруун талд төрийн хүндэт харуул, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим жагсана. Талбай дээр хивс дэвсэж хөшөөний бамбарыг асаана.

8.3.2. Цэцэг өргөх цаг болоход найрал хөгжим "Зөвлөлтийн дайчдын хөшөө" аяыг эгшиглүүлж ёслол эхэлнэ. Хүндэт харуулын цэргүүд цэцгийг хос хосоороо барьж, хүндэтгэлийн алхаагаар явж дурсгалт газрын шороотой бичээсний өмнө дараалуулан байрлуулна. Цэцэг өргөгсөд хүндэтгэл илэрхийлээд хөшөөний мөнхийн галтай бамбарыг нар зөв тойрч хойд талаас эхлэн байраа эзлэн зогсоно.

8.3.3. Цэцэг өргөж дуусахад Оросын Холбооны Улс, Монгол Улсын төрийн дуулал, цэцэг өргөгсөд тарж явахад баярын марш эгшиглүүлнэ.

## **8.4. Г.К.Жуковын хөшөөнд**

8.4.1. Төрийн хүндэт харуул, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим хөшөөний баруун талд жагсана. Хөшөө рүү гудаслаг нарийн хивс дэвсэж, хивсний үзүүрээс эхлэн цэцгийг өргөх дарааллаар байрлуулна.

8.4.2. Цэцэг өргөх цаг болоход хүндэт харуулын цэргүүд цэцгийг хос хосоороо барьж хүндэтгэлийн алхаагаар явж, хөшөөний өмнө дэвссэн хивс дээр дарааллын дагуу ээлжлүүлэн байрлуулна. Цэцэг өргөгсөд цэцгийн өмнө мэхийн ёслоод хөшөөг нар зөв тойрч хөшөөний зүүн талд гаран цэцэг өргөсөн дарааллаар цуван зогсоно.

8.4.3. Цэцэг өргөж дуусахад Оросын Холбооны Улс, Монгол Улсын төрийн дуулал, цэцэг өргөгсөд тарж явахад "Ялалт" марш эгшиглүүлнэ.

## **8.5. "Хувьсгалт Монгол" танкийн хөшөөнд**

8.5.1. Хөшөөний хойд талбайн зүүн талд төрийн хүндэт харуул, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим жагсана.

8.5.2. Цэцэг өргөх цаг болоход хүндэт



харуулын цэргүүд цэцгийг хос хосоороо барьж хүндэтгэлийн алхаагаар явж хөшөөний өмнө дараалуулан байрлуулна. Цэцэг өргөгсөд хүндэтгэл илэрхийлээд талбайн баруун талд байраа эзлэн зогсоно.

8.5.3. Цэцэг өргөж дуусахад Оросын Холбооны Улс, Монгол Улсын төрийн дуулал, цэцэг өргөгсөд тарж явахад "Ялалт" марш эгшиглүүлнэ.

## 8.6. "Монгол Ард" эскадрилийн хөшөөнд

8.6.1. Хөшөөний хойд талд төрийн хүндэт харуул, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим жагсана.

8.6.2. Цэцэг өргөх цаг болоход хүндэт харуулын цэргүүд цэцгийг хос хосоороо барьж хүндэтгэлийн алхаагаар явж хөшөөнд дараалуулан байрлуулна. Цэцэг өргөгсөд хүндэтгэл илэрхийлээд хөшөөний өмнө хэсэгт гаран цэцэг өргөсөн дарааллаар цуван зогсоно.

8.6.3. Цэцэг өргөж дуусахад Оросын Холбооны Улс, Монгол Улсын төрийн дуулал, цэцэг өргөгсөд тарж явахад "Ялалт" марш эгшиглүүлнэ.

## 8.7. Хэлмэгдэгсдийн дурсгалын хөшөөнд

8.7.1. Хөшөөний баруун талбайд төрийн хүндэт харуул, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим жагсана. Хөшөө хүртэл гудаслаг нарийн хивс дэвсэж хивсний үзүүрээс эхлэн цэцгийг өргөх дарааллаар байрлуулна.

8.7.2. Цэцэг өргөх цаг болоход найрал хөгжим "Эмгэнэн дуурсах аялгуу" эгшиглүүлэн ёслол эхэлнэ. Хүндэт харуулын цэргүүд цэцгийг хос хосоороо барьж хүндэтгэлийн алхаагаар явж хөшөөний өмнө талд дараалуулан байрлуулна. Цэцэг өргөгсөд цэцгийн өмнө мэхийн ёслоод хөшөөг шатаар өгсөн нар зөв бүтэн тойрч хөшөөний зүүн талд

гаран цэцэг өргөсөн дарааллаар цуван зогсоно.

8.7.3. Цэцэг өргөж дуусахад төрийн дуулал, цэцэг өргөгсөд тарж явахад "Алдар" марш эгшиглүүлнэ.

## 8.8. Хэлмэгдэгсдийн булшинд

8.8.1. Булшны гадна зүүн талбайд төрийн хүндэт харуул, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үлээвэр найрал хөгжим жагсана. Булшны хайсны хаалга хүртэл гудаслаг нарийн хивс дэвсэж цэцгийг өргөх дарааллаар байрлуулна.

8.8.2. Цэцэг өргөх цаг болоход найрал хөгжим "Эмгэнэн дуурсах аялгуу" эгшиглүүлж ёслол эхэлнэ. Хүндэт харуулын цэргүүд цэцгийг хос хосоороо барьж хүндэтгэлийн алхаагаар явж булшны хайсан дотор орж булшны өмнө тавцанд дараалуулан байрлуулна. Цэцэг өргөгсөд цэцгийн өмнө мэхийн ёслоод булшны хайсны гадна талаар нар зөв тойрон явж булшны баруун хэсэгт цэцэг өргөсөн дарааллаар цуван зогсоно.

8.8.3. Цэцэг өргөж дуусахад төрийн дуулал, цэцэг өргөгсдийг тарж явахад "Алдар" марш эгшиглүүлнэ.

## Ес. Төрийн ёслолын ахлал

9.1. Төрийн ёслолын ахлалыг дараахь байдлаар тогтооно:

Ерөнхийлөгч,  
УИХ-ын дарга,  
Ерөнхий сайд,  
Дээд шүүхийн ерөнхий шүүгч,  
Үндсэн хуулийн цэцийн дарга,  
УИХ-ын дэд дарга,  
УИХ-ын гишүүн,  
Засгийн газрын гишүүн,  
Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга,  
Нийслэлийн Засаг дарга,  
Төрийн хянан шалгах хорооны дарга,

Улсын ерөнхий прокурор,  
 Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга,  
 УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн  
 бичгийн дарга,  
 Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
 дарга,  
 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн  
 нарийн бичгийн дарга,  
 Монгол банкны ерөнхийлөгч,  
 Үнэт цаасны хорооны дарга,  
 Үндэсний статистикийн газрын дарга,  
 Төрийн захиргааны албаны зөвлөлийн  
 дарга,  
 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
 Хурлын Тэргүүлэгчдийн дарга,  
 Аймгийн Засаг дарга,  
 Үндсэн хуулийн цэцийн гишүүн,  
 Дээд шүүхийн шүүгч,  
 Звэсэгт хүчний Ерөнхий штабын дарга,  
 Яамны Төрийн нарийн бичгийн дарга,  
 Засгийн газрын тохируулагч  
 агентлагийн дарга,  
 УИХ-ын Тамгын газрын ЕНБД-ын  
 орлогч,  
 Засгийн газрын ХЭГ-ын орлогч дарга,  
 Ерөнхийлөгчийн зөвлөх,  
 УИХ-ын даргын зөвлөх,  
 Ерөнхий сайдын зөвлөх,  
 Засгийн газрын хэрэгжүүлэгч  
 агентлагийн дарга,  
 Монгол банкны дэд ерөнхийлөгч,  
 Ерөнхий прокурорын орлогч,  
 Төрийн хянан шалгах хорооны ерөнхий  
 нарийн бичгийн дарга,  
 Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн  
 бичгийн дарга,  
 ТӨ-И, ТӨ-П-т хамаарах албан тушаал  
 хашиж байсан төрийн зүтгэлтнүүд.

(Холбогдох тогтоолуудыг хавсаргав)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 7 дугаар Улаанбаатар  
 сарын 3-ны өдөр Дугаар 41 хот

Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд  
 хамаарах төрийн албан тушаалын зэрэг

зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалын  
 зэрэглэлийг тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн албаны тухай хуулийн 5  
 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан Төрийн  
 өндөр албан тушаалтны зэрэг дэвд  
 хамаарах төрийн албан тушаалын зэрэг  
 зиндаа болон түүнтэй адилтгах албан  
 тушаалын зэрэглэлийг хавсралт ёсоор  
 баталсугай.

2.Төрийн өндөр албан тушаалтны  
 зэрэг дэвд хамаарах төрийн албан  
 тушаалын зэрэг зиндаатай болон яамд,  
 төрийн бусад байгууллагын төрийн  
 захиргааны албан тушаалын ангилал,  
 зэрэглэлтэй адилтгах улс төрийн болон  
 төрийн тусгай албан тушаалын зэрэглэл  
 тогтоохыг Засгийн газарт зөвшөөрсүгэй.

ДАРГА Н.БАГАБАНДИ  
 МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
 ТОГТООЛ

1995 оны 7 дугаар Улаанбаатар  
 сарын 3-ны өдөр Дугаар 42 хот

Төрийн зарим байгууллагын удирдах албан  
 тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох  
 тухай

Төрийн албаны тухай хуулийн 7  
 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасныг  
 үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ  
 нь:

Улсын Их Хурал, Ерөнхийлөгч,  
 Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын  
 Ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн  
 цэцийн ажлын албаны удирдах албан  
 тушаалын ангилал, зэрэглэлийг  
 хавсралтын ёсоор баталсугай.

ДАРГА Н.БАГАБАНДИ

